

**ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ**

ГЕГ-ын даргын 2013 оны А/199 дүгээр тушаалын Хавсралт 1

Д/д	Үйлчилгээний хураамж	Хураамжийн хэмжээ
1	Гаалийн хилээр нэвтэрсэн бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийхэд: -үндсэн мэдүүлэг бүрт -нэмэлт мэдүүлэг бүрт	7000 төгрөг 1200 төгрөг
2	Гаалийн хяналтын түр бүсэд захиалгаар үйлчилэхэд (гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамж дээр нэмж тооцно.) 1 цагийн хураамж: -ажлын өдөр -ажлын бус цаг, амралт, баярын өдрүүдэд	4000 төгрөг 8000 төгрөг
3	Хувь хүний нэр дээр ирсэн улс хоорондын шуудангийн илгээмж болон зорчигчийн бараа арилжааны шинж чанартай бол тооцоот хуудсаар гаалийн бүрдүүлэлт хийхэд:	1200 төгрөг
4	Авто тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй бараанд ачааны манифест (А1) бичихэд манифест тутамд:	3000 төгрөг
5	Барааг гаалийн баталгаат бүсэд оруулахад төлөх шимтгэлийг барааны үнийн дүнгээс тооцон гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэгч төлнө.	0.1 хувь
6	Гаалийн үндсэн болон нэмэлт мэдүүлэг, гаалийн мэдүүлгийн хавсралтг, ачааны манифестыг зуучлагч байгууллагуудад худалдахад: -1 багц нь	1200 төгрөг
7	Экспортод гаргах нүүрс болон уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж: -тонн тутамд	1500 төгрөг
8	Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд тавьсан нэг удаагийн ломбоны үнэ	1000 төгрөг

Татвар болох жишээ:

(Онцгой албан татвартай барааны /суудлын автомашины/ татварыг тооцож үзье.)
Иргэн Л Япон улсаас 2011 онд үйлдвэрлэгдсэн, хөдөлгүүрийн багтаамж нь 2000 см3 Mark-II машиныг 3000 ам.доллаараар худалдан авсан бөгөөд уг машиныг монголд оруулж ирэх тээврийн зардал болон холбогдох зардал нийт 2500 ам.доллар төлсөн гэж үзвэл ямар хэмжээний татвар төлөхийг тооцож үзье.

- ХҮ - худалдаж авсан үнэ;
- З - тээврийн зардал болон бусад зардал;
- ГҮ - гаалийн үнэ (зах зээлийн үнэ);
- Х - тухайн өдрийн гаалийн бүрдүүлэлтэд мөрдөж байгаа ам.долларын ханш (1 \$=2'350 төгрөг гэж тооцов.)
- ГТ - Гаалийн татвар (5%)
- ОАТ - Онцгой Албан Татвар
- НОАТ - Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (10%)

1. $ГҮ=(ХҮ+З)*Х$
 $ГҮ=(3'000+2'500)*2'350=12'925'000$ төгрөг

2. $ГТ=ГҮ*5\%$
 $ГТ=12'925'000*5\%=646'250$ төгрөг

3. Суудлын автомашин нь 2010 онд үйлдвэрлэгдсэн, хөдөлгүүрийн багтаамж нь 2000 см³ тул Онцгой албан татварын тухай хуулийн дагуу **3'200'000 төгрөгийн ОАТ** ногдуулна.

4. $НОАТ=(ГҮ+ГТ+ОАТ)*10\%$
 $НОАТ=(12'925'000+646'250+3'200'000)*10\%=1'677'125$ төг
ТАТВАРЫН ДҮН: 646'250 + 3'200'000 + 1'677'125 буюу Таны импортлосон автомашинд нийт **5'523'375 төгрөгийн татвар** ногдох тооцоо гарч байна.

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулг



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлтөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:
 Сүхбаатар дүүрэг, “Их тойруу-81/1”,
 Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 350049
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: http://www.customs.gov.mn



**МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

**ГААЛИЙН БОЛОН
БУСАД ТАТВАР, ХУРААМЖ**



**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

1. "Гаалийн албан татвар" гэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн тарифын дагуу ноогдуулах, хураах, төлөх албан татварыг хэлнэ. Гаалийн татвар тогтоох хэлбэр нь:

- Гаалийн үнээс хувиар;
- Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр;
- Дээрх 2 хэлбэрийг дангаар эсхүл хослуулан;
- Дээрх 2 хэлбэрээс гаалийн өндөр татвартайг нь сонгоно.

"Гаалийн үнээс хувиар тооцох хэлбэр":

Энэ хэлбэрээр гаалийн татвар тооцоход дараах томъёог хэрэглэнэ.

$$ГТ = ГҮ \times Т1$$

ГТ - гаалийн татвар

ГҮ - гаалийн үнэ

Т1 - үнээс тооцох тарифын хувь хэмжээ

"Биет хэмжигдэхүүнээс тооцох хэлбэр":

Энэ хэлбэрээр гаалийн татвар тооцоход дараах томъёог хэрэглэнэ.

$$ГТ = ТХ \times Т2$$

ГТ - гаалийн татвар

ТХ - татвар тооцох барааны тоо хэмжээ, жин буюу биет хэмжигдэхүүн

Т2 - тоо хэмжээ, жингээс тооцох тарифын хувь хэмжээ

2. "Онцгой албан татвар" Онцгой албан татварын тухай хуулийн дагуу импортын бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи, автобензин, дизелийн түлш, автомашинд онцгой татвар /ОАТ/ ногдуулдаг. Эдгээр бараанд ОАТ ногдуулахдаа дараах биет нэгжийг үндэслэл болгоно:

Онцгой албан татварын тухай хуулийн 5.1

Д/д	ОАТ ногдуулах барааны нэр, төрөл	ОАТ ногдуулах биет нэгж
1	Бүх төрлийн согтууруулах ундаа	1 литр
2	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг
3	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 килограмм
4	Автобензин, дизелийн түлш	1 тонн
5	Суудлын автомашин	1 ширхэг

2.1. Импортын согтууруулах ундаа, тамхины Онцгой албан татварын хэмжээ

ОАТ ногдуулах барааны нэр, төрөл		Биет нэгж	Ногдуулах ОАТ-ын хэмжээ /төг/	
			2018	2019
Бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал, спиртлэг бусад ундаа	25 хүртэл хатуулагтай	1 литр	3,190	3,335
	25-40 хүртэл хатуулагтай	1 литр	6,380	6,670
	40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	14,355	15,000
Бүх төрлийн коньяк, виски, ром, джин	25 хүртэл хатуулагтай	1 литр	7,975	8,340
	25-40 хүртэл хатуулагтай	1 литр	15,950	16,700
	40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	19,140	20,010
Бүх төрлийн дарс	25 хүртэл хатуулагтай	1 литр	800	835
	25-40 хүртэл хатуулагтай	1 литр	7,180	7,505
Бүх төрлийн пиво		1 литр	320	335
Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи		100 ширхэг	3,830	4,000
Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи		1 килограмм	2,870	3,000

2.2. Импортын автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварын хэмжээ

Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төг/		
	Автобензин		Дизелийн түлш
	90 хүртэл октантай	90 болон түүнээс дээш октантай	
Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0	0	0

2.2.-ын үргэлжлэл

Ханх, Ульханмайхан	0	0	0
Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг	50 000	30 000	70 000
Эрэнцав	0	0	0

2.3. Импортын суудлын автомашины Онцгой албан татварын хэмжээ

Хөдөлгөөний цилиндрийн багтаамж /см ³ /	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
	Үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа /жилээр/			
	0-3 жил	4-6 жил	7-9 жил	10 ба түүнээс дээш жил
1500 ба түүнээс доош	750 000	1 600 000	3 350 000	10 000 000
1501-2500	2 300 000	3 200 000	5 000 000	11 700 000
2501-3500	3 050 000	4 000 000	6 700 000	13 350 000
3501-4500	6 850 750	8 000 000	10 850 000	17 500 000
4501 ба түүнээс дээш	14 210 000	27 200 000	39 150 000	65 975 000

3. "Автобензин, дизелийн түлшний албан татвар" Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуульд импортоор оруулж ирсэн автобензин, дизелийн түлшинд дараах хэмжээгээр албан татвар ногдуулна.

Албан татвар ногдуулах автобензин, дизелийн түлш	Нэг тоннд ногдуулах албан татварын хэмжээ /төгрөгөөр/
1. Автобензин -90 хүртэл октантай -90-ээс дээш октантай /шинжилгээний аргаар тодорхойлсон/	20350 25700
2. Дизелийн өвөл, зуны түлш	2140

4. "Нэмэгдсэн өртгийн албан татвар" Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд импортын бараанд 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/ ногдуулна. Импортын барааны НӨАТ тооцохдоо:

$$НӨАТ = (ГҮ + ГТ + ОТ + БТ) * Т3$$

ГҮ - гаалийн үнэ

БТ - бусад татвар

ГТ - гаалийн татвар

Т3 - НӨАТ-ын хувь

ОТ - онцгой татвар